



**АТАР-ӨРГӨӨ ХУВЬЦААТ КОМПАНИЙН
ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН
ТОГТООЛ**

20 23 оны 02 сарын 03 өдөр

№ 17

Улаанбаатар хот

**ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН
ТОГТООЛД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ
ТУХАЙ**

Компанийн тухай хуулийн 69 дүгээр зүйлийн 69.6, 76 дугаар зүйлийн 76.1.3., 76.1.18, Компанийн дүрмийн 7 дугаар зүйлийн 7.32.3., Санхүүгийн зохицуулах хорооны 2018 оны 377 дугаар тогтоол, тус Хорооны 2023 оны 01 сарын 31-ний өдрийн 9/355 дугаартай албан даалгаварыг тус тус үндэслэн **ТОГТООХ НЬ:**

1. “Атар өргөө” ХК-ийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн 2022 оны 12 дугаар сарын 27-ны өдрийн 14 дугаартай тогтоолд заасан хувьцаа эзэмшигчдийн хурлын товйг хойшлуулж 2023 оны 3 дугаар сарын 03-ны өдрийн 09 цаг 00 минутанд /Хан-Уул дүүргийн 3 дугаар хороо, Чингисийн өргөн чөлөө-20, Атар-Өргөө ХК-ны байрны хурлын танхим/-д хуралдуулсугай.
2. Хурлаар эзэмшигчдийн ээлжит бус хурлаар дор дурдсан асуудлуудыг хэлэлцүүлэхээр тогтоосугай. Үүнд:
 - a. Хувьцаат компанийг хязгаарлагдмал хариуцлагатай компани болгон хэлбэрийг өөрчлөх;
 - b. Компанийг өөрчлөх төслийг танилцуулж, дүрмийг шинэчилж батлах;
 - c. Компанийн тухай хуулийн 56 дугаар зүйлийн 56.3 дахь заалтын дагуу хувьцааны хяналтын багцыг худалдахаар санал болгосон хувьцаа эзэмшигчдийн асуудлаар тусгайлан шийдвэр гаргуулах асуудлыг хэлэлцүүлэх.
3. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хуралд бэлтгэх, зохион байгуулах комиссыг дор дурьдсан бүрэлдэхүүнтэйгээр зохион байгуулсугай.
 - i. Комиссын дарга Б. Мөнхдалай /ТУЗ-ийн дарга/
 - ii. Гишүүн С. Баярмаа /ТУЗ-ийн нарийн бичгийн дарга/
4. Хурал бэлтгэх зохион байгуулах комисст даалгах нь:
 - a. Компаний ээлжит бус хурлыг хуралдуулах тухай Хурлын мэдэгдлийг холбогдох бичиг баримтын хамт 2023 оны 02 сарын 07-ны дотор Санхүүгийн зохицуулах хороо болон арилжаа эрхлэх байгууллагад хүргүүлэх,
 - b. Компаний хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурал хуралдуулах тухай зар мэдээг 2023 оны 02 сарын 08-ны өдрийн дотор олон нийтийн мэдээллийн хэрэгслээр /өдөр тутмын сонин телевиз/ болон компани, арилжаа эрхлэх байгууллагын цахим хуудсаар хувьцаа эзэмшигчдэд мэдээлэх,
 - c. Энэхүү мэдээллийг 15 хоногийн дараа анх мэдээлсэн хэлбэрийн дагуу дахин мэдээлэх,

- d. Хувьцаа эзэмшигчдийн хурлаар хэлэлцэх асуудал, тэдгээрийн танилцуулга, хурлаас гарах шийдвэрийн төсөл, санал авах хуудсыг үнэт цаасны брокер, дилерийн компанид хэвлэмэл болон цахим хэлбэрээр 2023 оны 02 сарын 07-ны дотор хүргүүлэх,
 - e. Хурлаар хэлэлцэх асуудал, гарах шийдвэрийн төсөл болон хувьцаа эзэмшигчдэд танилцуулах бичиг баримтыг 2023 оны 02 сарын 03-ны өдрөөс 2023 оны 02 сарын 24-ны өдрийн дотор хувьцаа эзэмшигчдэд танилцуулж, саналын хуудсаар санал авах
- 5. Ээлжит бус хурлын “Санал авах хуудас”-ны загварыг энэхүү тогтоолын хавсралтаар баталсугай.
 - 6. Ээлжит бус хуралд оролцох эрхтэй хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалт гаргах бүртгэлийн өдрийг 2023 оны 1 дүгээр сарын 20-ны өдрөөр тогтоосугай.
 - 7. Хуралд биеэр оролцох боломжгүй хувьцаа эзэмшигчдийн санал авах хуудсыг хүллэж авах сүүлийн хугацааг 2023 оны 02 сарын 28-ны 17.00 цагаар тогтоосугай.
 - 8. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлын даргаар Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга Б. Мөнхдалайг сонгосугай.
 - 9. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлын Тооллогын комиссын даргаар Ц.Мөнхтуул, гишүүдээр М.Солонго, Т.Сэрээтэр нарыг тус тус томилсугай.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ
ЗӨВЛӨЛИЙН ДАРГА



Б.МӨНХДАЛАЙ